

2008.06.12

Дугаар 145

“Монголын төмөр зам” төрийн өмчит ХК-ийн
хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 2.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 82 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2008 оны 189 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Монголын төмөр зам” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 226000 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэсүгэй.

2.“Монголын төмөр зам” ХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголын төмөр зам” ХК /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ